

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 оны 07 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Тус компани нь 2017 оны эхний хагас жилийн ашгийн төлөвлөгөөний биелэлт нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Өнөөдрийн байдлаар компанийн хэмжээнд ШҮ-ний 21 үндсэн салбар; 23 аймаг, дүүргийн газар; 239 сумын салбарт нийт 913 хүн ажиллаж байна. Улаанбаатар хотод 383, хөдөө орон нутагт 530 ажилтнууд ажиллаж байгаагаас 70 хувь нь эмэгтэй, 30 хувь нь эрэгтэй байна.

2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндсэн 7 чиглэлээр, нийт 323 ажил төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 58,17 хувьтай байна.

Тайлант хугацаанд, шуудангийн үндсэн болон уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг идэвхжүүлэн хөгжүүлэх, шуудангийн үйлчилгээний орлогын шинэ эх үүсвэрийг бий болгох, бүтээгдэхүүн үйлчилгээг шинээр нэвтрүүлж эхлүүлэх гэсэн гурван зорилтыг дэвшүүлэн дараах байдлаар ажиллалаа.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Компанийн ажилтнуудтай байгуулах хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж, аймгийн ШҮГ-ын дарга, Улаанбаатар хотын бүх ажилтнуудтай хөдөлмөрийн болон эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг шинэчлэн хийлээ.

Компанийн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 147, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 219 ширхэг гарсан ба 1484 ширхэг албан бичиг ирснээс 1337 ширхэг нь хариугүй, 147 ширхэг нь хариутай албан бичиг ирсэн. Хариутай бичгийн шийдвэрлэлт 83% , 17% буюу 24 албан бичиг шийдвэрлэгдэх шатандаа явж байна. Ажилтнуудаас 134 ширхэг өргөдөл хүлээн авсны 96 ширхэг буюу 71%-ийг шийдвэрлэсэн байна.

Компанийн статус өөрчлөгдсөнтэй холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн компанийн эрхэм зорилго, зорилтын хүрээнд “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж, “Монгол шуудан” ХК болон шуудангийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан гэрээг хэлэлцэн дүгнэж, шинэчлэн байгууллаа. Түүнчлэн “Сонгон шалгаруулалтын журам”, “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний KPI системийн нэвтрүүлэх журам”, “Аттестатчилал явуулах журам”, “Орон сууцны дэмжлэг үзүүлэх журам”, “Сургалт явуулах журам”, “Харилцаа үйлчилгээний стандарт”, “Өргөдөл, гомдлыг бүртгэн шилжүүлэх, шийдвэрлэх журам”, “Цаг бүртгэл, ажлын цаг ашиглалтын журам”, “Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалт”, “Архивын үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам”, “Албан хэрэг хөтлөлтийн журам”-уудыг шинэчлэн боловсруулж, журмын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, захиргаа ҮЭХ-ны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-г өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж, ажилтны ар гэрт нь гачигдал гарсан ажилтан нарт буцалтгүй тусламж тэтгэмжийг үзүүллээ. Ахмад настнуудаа сар шинийн баяраар хүлээн авч, нэмэгдэл тэтгэмж олгожээ.

Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 20 ажилтанд нийт 100 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг үзүүлсэн.

Компанийн хүргэгч жолооч нарын цалинг 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс тус бүр 50 мянган төгрөгөөр нэмэгдүүллээ.

Харилцаа холбооны 96 жилийн ойн арга хэмжээг угтан, компанийн спорт арга хэмжээг зохион байгуулж шилдэг баг тамирчдыг салбарын спортын тэмцээнд оролцуулан, багаараа тэргүүн дэд байр эзэлж, мөнгөн медаль хүртсэн амжилт гаргалаа.

Түүхт ой, тэмдэглэлт өдрүүд болох Ардын хувьсгалын 96 жилийн ойн арга хэмжээ, Орон нутгийн ажилтнуудын удирдах ажилтнуудын зөвлөлгөөн, Ази Европыг холбосон транзит шуудангийн үйлчилгээг эхлүүлэх ажлын хүрээнд Монгол, Орос, Хятадын шуудангийн байгууллагуудын хамтарсан уулзалт зэрэг ажлуудыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, олны талархлыг хүлээн ажиллаж байна.

Архивт хадгалах хугацаа нь дууссан Шуудангийн дагавруудыг нэг бүрчлэн бүртгэж, оноор ялган төрөлжүүлж, Баримт бичиг нягтлан шалгах комиссын 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн №01 тоот хурлаар батлуулж, устгал хийсэн.

2017 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/04 тоот тушаалаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журам”, “Компанийн ажилтнуудын мөрдөх аюулгүй ажиллагааны журам”, “ХАБЭА-н аюулгүй ажиллагааны зааварчилгааны журам”-уудыг батлуулан, мөрдлөг болгон ажиллаж байна.

“Сургалтын журам”-ыг шинэчлэн батлуулж, танилцуулах сургалт, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Гадаад хэргийн яамнаас зохион байгуулсан “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын статистикийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, олон улсын чиг хандлага” сэдэвт сургалт семинар, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг сурталчилах зорилго бүхий “Хэрэглэгчийн төв”-ийн ажилтнуудад зориулсан сургалт, Олон улсын агаарын тээвэрлэгчдийн нэгдсэн холбооноос зохион байгуулсан “Агаарын тээврийн аюултай ачааны дүрмийн сургалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулсан “Цахим худалдан авах” ажиллагааны сургалтанд ажилтнуудаа хамрууллаа.

Тайланд Улсын Ази номхон далайн болон дэлхийн шуудангийн байгууллагын ажилтнуудын сургалтын төвд “Үйлчилгээний чанарын стандарт”-ын сургалт, “Интернет худалдаанд шуудангийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах” сургалт, “Эдийн засгийн” сургалт, Австралийн Сидней хотод болсон Дэлхийн шуудан холбоо, Дэлхийн гаалийн байгууллагуудын хамтран зохион байгуулсан “Гааль-Шуудан” сэдэвт сургалтанд тус бүр нэг нэг ажилтныг сургалаа.

Санхүү

НӨАТ-ын буцаан олголт, www.ebarimt.mn-ийн өөрчлөлт, НӨАТ-ын баримт хэвлэх, POS-ын системийг нэвтрүүлж байна. Гарсан НӨАТ-ын алдааг тухай бүрт нь засуулан, сар бүр тайланг цаг тухайд нь гарган өгч ажилласан.

Найдваргүй авлагыг ТУЗ-ийн хурлаар оруулан батлуулж, 318.6 сая төгрөгийн авлагыг дансанд бичилт хийж хаасан.

Төрийн болон орон нутгийн өмчийг 4 жилд нэг удаа тоолдог нэгдсэн тооллогын материал, Статистикийн ерөнхий газраас 5 жилд нэг удаа гаргадаг статистик судалгаа, Үндэсний Татварын ерөнхий газраас ирүүлсэн судалгаа, Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн шалтгалтуудад хамрагдсан. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2 жилд нэг удаа хийдэг, төлөвлөгөөт шалгалтанд хамрагдаж, шалгалтын дүнг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын даргын зөвлөлийн хуралд танилцуулан ажиллав.

Компанийн худалдан авалтын төлөвлөгөөг олон нийтэд зарлан, шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж, Засгийн газар, Сангийн яамны www.shilendans.gov.mn, www.pmmis.mof.gov.mn сайтуудад төлөвлөгөөг байршуулах, худалдан авалтыг зарлах, хөтлөх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Компанийн дугтуйны үйлдвэрт үйлдвэрлэгддэг болон зайлшгүй шаардлагын үүднээс гэрээгээр татан борлуулдаг нийт 17 төрлийн дугтуйны нэг бүрийн өртөг, худалдах үнийг зах зээлийн нөхцөл шаардлагад нийцүүлж, шинэчлэн тогтоон, тушаалаар баталгаажуулан мөрдүүлсэн.

Монгол улсыг засгийн газраас худалдан авах ажиллагааны үйл явцыг хурдан шуурхай, олон нийтэд хүртээлтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах зорилгоор “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем” бий болгосон бөгөөд тус системийн дагуу “Монгол Шуудан” ХК нь www.tender.gov.mn сайтад 2017 оны худалдан авах ажиллагааг бүртгүүлэн, зарласан тендерийг оруулан ажиллаж байгаа.

Хаан банк болон Худалдаа хөгжлийн банктай хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар хот дахь шуудангийн үйлчилгээний 25 салбарт төлбөрийн карт уншигч машин /Пос машин/ байршуулсан.

Компанийн “Эд хөрөнгийн харилцааг зохицуулах” журмыг боловсруулж, ТУЗ-өөр батлууллаа.

Дотоодын хяналт, шалгалт

Компанийн Гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу Улаанбаатар хотын Шуудангийн үйлчилгээний бүх салбар нэгжүүдэд, 5 аймгийн Шуудангийн үйлчилгээний газар /ШҮГ/-уудад 16 хоногийн хугацаатай, санхүүгийн хяналт шалгалтыг явууллаа.

Дээрхи ШҮГ, ШҮС-т хяналт шалгалтыг явуулахдаа Монгол Улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Шуудангийн тухай” зэрэг хуулиуд, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал болон компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан дотооддоо мөрдөх дүрэм, журмын биелэлтийг хангуулах, санхүүгийн баримт болон ажил гүйлгээгээр илэрсэн зөрчил дутагдлыг засч залруулах, гэм буруутай этгээдэд хариуцлага ногдуулах, байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хэрэг зөрчлийг дахин гарахаас сэргийлэн таслан зогсоох, багасгахад чиглүүлэн ажиллалаа.

Цаашид аймаг, хотын шуудангийн салбар нэгжүүдэд санхүүгийн болон технологийн хяналт шалгалтыг тогтмолжуулж, сургалт, семинар зохион байгуулах, хариуцлага сахилгыг өндөржүүлэх талаар байнга анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Хоёр. Шуудангийн үндсэн болон уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг идэвхжүүлэн хөгжүүлэх ажлын хүрээнд

Шуудангийн үндсэн үйлчилгээний нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн байна. Нэр төрлөөр нь авч үзвэл, 12 нэр төрлийн үйлчилгээний орлого өссөн, 12 нэр төрлийн үйлчилгээний орлого буурсан үзүүлэлттэй байна.

Хүргэлтийн үйлчилгээ

Төрийн байгууллагуудын хооронд А бүсийн хүргэлтийг 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 20А, 38, 44, 46, 46А, 48-р салбаруудаар зохион байгуулан, он гарсанаас хойш 12 байгууллагыг шинээр нэмж эхний хагас жилд нийт 2725 ширхэг албан бичиг өдөртөө гардуулагдсан байна. Хүргэгч нарын гар утасны GPS болон гардуулалтын явцыг өдөр бүр хянаж, гардуулалтыг сайжруулах зорилттой ажиллаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран явуулж байгаа гибрид шуудан, скайтелийн гибрид шуудан, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн торгуулийн хуудсыг ялган боловсруулж, хүргэн ажиллав. Гибрид шуудангийн үйлчилгээг Дархан-Уул, Орхон, Өвөрхангай аймгуудад нэвтрүүлсэн. Цаашид сумдын ШҮС сүлжээнд холбогдож, компьютероор хангагдвал энэхүү үйлчилгээ нэвтрэх бүрэн боломжтой юм.

Хэрэглэгчийн хүсэлтийн дагуу гадаад паспорт 2385 ширхэг, Улсын бүртгэлийн гэрчилгээ 104 ширхэгийг хүлээн авч хүргэв.

Хаяг тодорхойгүй, бүрэн бус хаягтай илгээмжийг Нийслэлийн иргэний бүртгэлийн газраас хаяг утсыг тодруулж 8 илгээмжийг эзэнд нь гардуулсан ба www.facebook.com, www.yahoo.com хаягаар нийт 185 хүнд хариу бичиж, 64 хүнд TOEFL-ийн шалгалтны хариуг нь гардуулав.

Шуудангийн илгээмжийн хүргэлтийг сайжруулахын тулд Бямба, Ням гарагийн хүргэлтийн ажлыг 21, 24, 32, 37, 40, 51 зэрэг салбарт зохион байгуулж нийтдээ 3943 ширхэг илгээмжийг хаягт эзэнд нь гардуулжээ.

EZPOST буюу хэрэглэгчээс очиж авах үйлчилгээг 21, 24, 28, 34, 38, 46, 48, 49-р салбаруудаар авч эхэллээ.

Дүнжингарав, Мишээл, Драгон худалдааны төвд байрлах “Нэг цэгийн үйлчилгээний нэгдсэн төв”-өөс гарах бүтээгдэхүүн үйлчилгээг хаягаар хүргэн өгч шуудангийн үйлчилгээг үзүүлж байна.

Дүнжингарав салбарт лицензийн төв, Оюуны өмчийн улсын бүртгэлийн ерөнхий газрын аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлж эхэлснээр 520 ширхэг жолооны үнэмлэх, 311 ширхэг гадаад паспорт хүргэх захиалга авч байгаа ба энэ тоо цаашид өсөх хандлагатай байна.

Оюуны өмчийн улсын бүртгэлийн ерөнхий газартай байгуулсан гэрээний дагуу гадаад паспортыг хаягаар хүргэх ажлыг идэвхжүүлэн хөгжүүлэх чиглэлээр гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний цахим үнэмлэх нийслэлийн 6 дүүрэгт багцаар хүргэх үйлчилгээг эхлүүлэн 44 ширхэгийг хүргэж гардууллаа.

Хэвлэл захиалгын үйлчилгээ

Эхний хагас жилд хэвлэл захиалгын гарын авлага 20 мянган ширхэг хэвлүүлэн гаргасан ба гарын авлагын өртгийг бууруулах зорилгоор реклам байршуулан реклам сурталчилгааны орлогыг нэмэгдүүлсэн болно. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэвлэл захиалгыг онлайн хэлбэрт шилжүүлж, хэвлэл захиалгын гарын авлагыг файл хэлбэрээр харилцагч байгууллагуудад шилжүүлэн, www.postnews.mn сайтаар хэвлэл захиалгыг онлайн хэлбэрээр авч эхэлсэн. Улаанбаатар өглөө эртийн хүргэлтийг 04.00-09.00 цагийн хооронд хүргэж, хагас жилийн байдлаар 94 албан байгууллагын 72615 ширхэг хэвлэлийн хүргэжээ.

Марк, үнэт цаасны үйлчилгээ

Тайлант хугацаанд “Тахиа жил”, “9 эрдэнэ”, “Галт тэрэгний зүтгүүр” сэдэвт маркийн анхны өдрийн дугтуй болон танилцуулгыг үйлдвэрлэн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулан, гүйлгээнд гаргаж, сурталчлах, түгээх ажлыг зохион байгуулж ажилласан.

Үндсэн 6 төрлийн дугтуй, мөнгөний дугтуй, анхан шатны маягт, дэвтэр, кодуудыг өөрийн үйлдвэрт үйлдвэрлэв. Мөн “Ард санхүүгийн нэгтгэл” ХХК-ийн захиалгаар С5 цонхтой эрэн дугтуй, 2 төрлийн мөнгөний дугтуй, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-ний албан бланк, “Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар”, Зам тээврийн хөгжлийн яамны харьяа “Далайн захиргааны газар”, “Нийслэлийн прокурорын газар”-ын захиалгаар С4, С5 дугтуйг хийж нийлүүллээ.

Мөнгөний дугтуйны борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах зорилгоор өмнөх онд их борлогдсон мөнгөний дугтуйны өнгө, загварыг судлан, түүнийг дахин хэвлүүлэх, өдөр тутмын 10 сонинд үнэ төлбөргүй сурталчилгаа тавиулах, 5000 ширхэг мөнгөний дугтуйны брошюр хэвлүүлэн салбар нэгжүүдээр тараан таниулах, зэрэг ажлуудыг хийсний үр дүнд нийт 300,000 ширхэг мөнгөний дугтуй хэвлэж, үүнээс 278,896 ширхэгийг борлуулж, өмнөх оноос 112.3 мянган ширхэг буюу 67 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бичиг захидлын үйлчилгээ

МҮОНРТ-тэй хамран “Ээждээ захидал бичээрэй” захидлын уралдаан зохион байгуулж нийт 1000 орчим захидал хүлээн авсан. “Хөрөнгө оруулагч үндэстэн”-тэй хамтын ажиллагааны хүрээнд логотой, цонхтой дугтуй үйлдвэрлэн гаргаж, бизнес захидлаар хүргэн гардуулав. Улаанбаатар хотын болон хөдөө орон нутгийн иргэдийн хурлын бүх төлөөлөгчдөд хаяглагдсан албан бичгийг мэдээллийн бааз бүрдүүлэн хаяглаж хүргэх ажлыг зохион байгуулсан. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас зохион байгуулсан нээлттэй

хаалганы өдөрлөг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулж буй Нээлттэй хаалганы өдөрлөгүүдэд хэрэглэгчдээр ил захидал, бичиг захидал үнэгүй бичүүлэн, нийт 1500 орчим хэрэглэгчдэд шуудангийн үйл ажиллагааг танилцуулж, 1200 гаруй ил захидал, бичиг захидлыг үнэгүй бичүүлж хүлээн авсан. Харилцаа холбооны зохицуулах хорооноос зохиогдсон “Цахим орчин дахь гадуурхал” сэдэвтэй захидлын аянд нийт 2921 ширхэг захидал хүлээн авсан ба Багануур дүүрэг, Ховд аймаг, Дархан-Уул аймгаас шилдэг оролцогчид шалгарав. “Мундаг мааму” захидал, гар зургийн уралдааныг зохион байгуулж 15000 мянга гаруй ил захидлыг хүлээн авч захидал болон маркийн орлого, солилцооны тоог нэмэгдүүлсэн.

Буухиа шуудангийн үйлчилгээ

Буухиа шуудангийн үйлчилгээг өргөжүүлэх ажлын хүрээнд 63 улс руу хяналтын буухиа шуудан илгээж, хяналтын хугацааг амжилттай тогтоов. Дамжин өнгөрүүлэх шуудангийн байгууллага болон тээврийн байгууллагын нөхцөл боломжоос хамааран буухиа шуудангийн хамтын ажиллагаанд нэгдсэн 182 улсаас 78 улсыг нэмэгдүүлэн нийт 116 улстай буухиа шуудан солилцох боломжтой болоод байна.

Нэмэгдсэн улс орнуудтай 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс албан ёсоор буухиа шуудан солилцож эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Макао, Словак, Арабан Эмират, Вьетнам, Индонези, Кипр, Армен, Шинэ Зеланд, Латви, Киргизстан зэрэг улсууд руу буухиа шуудан илгээгдэж хяналтын хугацаандаа гардуулагдсан байна. Буухиа шуудан солилцож буй бүх улс орнуудад хүргэж, гардуулагдах хяналтын хугацааг шинэчлэн тогтоож мөрдөн ажиллаж байна. EMS-ийн үйлчилгээ эрхэлдэг улс орнуудын 2017 онд мөрдөх үндсэн стандартын дагуу буухиа шуудан солилцдог бүх улс орнуудтай EMSEVT 3,0 хувилбараар мэдээллээ солилцох тохиргоог IPS програмд хийн 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн мэдээллээ солилцож эхэллээ. Мөн энэ стандартын дагуу Leg 1 буюу экспортын стандартыг хийн ДШХ-оор батлуулсан бөгөөд энэхүү стандартыг 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна.

Улс хоорондын шуудан, илгээлтийн үйлчилгээ

Улс хоорондын буухиа шуудангийн үйлчилгээг дэлхийн 116 оронд үзүүлдэг болсонтой холбоотойгоор олон нийтэд сурталчлан таниулах идэвхжүүлэлтийн ажлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сошиал орчинд хийн ажиллаж байна.

Улс хоорондын гарах бичиг захидал, боодол, илгээлтийг хурдан шуурхай хүргэх тал дээр анхаарч хяналт тавин ажилласан ба Туркийн агаарын тээврээр дамжиж байгаа улс орнуудын шууданг төөрөх, саатах зэргээс урьдчилан сэргийлж, хуваарьт нислэгээс өмнө чиглэл маршрут, тоо ширхэг, жингийн талаарх мэдээллүүдийг Туркийн агаарын тээвэрт тогтмол өгч, тус улсаар дамжин илгээгдэж байгаа Европын орнуудын энгийн шуудан нь ажлын 3-10 хоногт хаягт эзэндээ хүргэгдэж байна.

Гаалийн газрын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 09-ний өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан бөгөөд уг өдөрлөгт УХШИГГ-тай хамтран оролцож гаалийн бүрдүүлэлтэй, хэрэглэгчид нь татвараа төлж чадахгүй болон удаан хугацаагаар гаалийн агуулахад хадгалагдаж байсан илгээмжүүдийг олгосон. Нийтдээ 30 ширхэг буухиа илгээмж, 20 ширхэг илгээлт, 8 ширхэг энгийн боодлыг хүлээн авагчид нь гардуулсан байна.

Гурав. Орлогын шинэ эх үүсвэр бий болгох талаар хийгдэж буй ажлын хүрээнд

Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Скайтел” ХХК-ийн авлагын захидлыг гибрид шуудангаар хүргэх үйлчилгээг эхлүүлсэн. Мөн “Мобиком” корпорацийн авлагын захидлыг хүргэх, “Хаан банк”-ны 90 гаруй картын төвүүдэд багцаар

карт хүргэх үйлчилгээ, “Хас банк”-ны харилцагчийн картыг хүссэн хаягаар хүргэх үйлчилгээг нэвтрүүлсэн, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн торгуулийн хуудасны хүргэлтийн үйлчилгээ, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн зарлан дуудах үйлчилгээний хүргэлтийн үйлчилгээ, мобикомын нэгж борлуулах үйлчилгээгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн компанит ажлын сонгуулийн эд зүйлсийг 21 аймагт хүргэх, гардуулах ажлыг тус тус зохион байгуулсан ажиллалаа.

Цаашид Татварын ерөнхий газрын татварын өрийн бичиг, ХХОАТ-ын буцаан олголтын тайланг гибрид шуудангаар хүргэх, Оюуч өмчийн улсын бүртгэлийн ерөнхий газрын гадаад паспортыг хаягаар хүргэх, иргэдийн цахим үнэмлэхийг багцаар хүргэх үйл ажиллагааг улам сайжруулах, идэвхжүүлэх талаар талууд санаачилга гарган ажиллаж байна.

Дөрөв. Тээвэр зууч, логистикийн үйлчилгээний ажлын хүрээнд

Замын-Үүд, Улаанбаатарын чиглэлд хийх логистик тээврийн давтамж, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор HD 700 маркийн автомашины буюу 20 тонны даацтай автомашиныг сард 6 удаа тээвэрлэлтэд явуулах, дүүргэлтийг ханган ажиллах, Эрээн-Бээжин, Бээжин-Эрээн чиглэлийн зорчигч тээврийн автобусанд сурталчилгааны материал тараах, байршлуулах, энэ чиглэлийн зорчигчийн ачааг Улаанбаатар хотын тодорхой бүсэд үнэгүй хүргэх, Улаанбаатар, Замын-Үүдийн чиглэлд бараа бүтээгдэхүүн нийлүүлдэг хувь хүн болон аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээгээ танилцуулж, санал тавих, даац ихтэй автомашиныг түрээслэх, ажиллуулах судалгааг хийж, гэрээний нөхцөл болон үнийн судалгаа хийх, автомашины шатахуун зарцуулалтыг хянаж, үйл ажиллагаагаа сайжруулах, зардал хэмнэх боломжуудыг судлах зэрэг ажлуудыг шат дараалалтай хийснээр логистикийн орлогыг 15-20 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Замын-Үүд дэх логистикийн төвийн аюулгүй байдлыг ханган ажиллаж, галын болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилга бүхий самбар хийн, гаднах орчны гэрэлтүүлэг, тусгал сайтай шөнийн камерийг байршуулан, ажилтнуудын ажлыг хөнгөвчлөх зорилгоор ачаа буулгах конвейр хийлгэн ажилд оруулсан.

“Сонгино хайрхан” АТТ буюу Драгон төвд шуудангийн ачаа тээвэр, тээш хадгалалтын төвийг Автотээврийн үндэсний төвтэй хамтран байгуулж, зорчигч тээврийн автобусаар явдаг дайвар ачааг нэгдсэн журамд оруулж, засвар үйлчилгээ хийсэн.

Хил дамнасан и-худалдаа буюу транзит шуудангийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Гаалийн ерөнхий газрын тавьсан шаардлагын дагуу Алтанбулаг дахь хилийн бүсэд шуудан солилцох төвийг байгуулж, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар БНСУ, АНУ, Япон улсад карго үйлчилгээг эхлүүлэхээр Олон улсын агаарын тээвэрлэгчдийн нэгдсэн холбооны мэргэшсэн үнэмлэхтэй ажилтан бэлтгэх сургалтад 2 ажилтан хамруулж, МИАТ-ийн карго агент болохоор хууль, эрх зүйн талаас нь судалгаа хийн ажилласан. Карго үйлчилгээний тариф гаргахаар БНСУ дахь хувийн каргонууд болон Монгол дахь карго үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн судалгааг гарган ажиллаж байна.

Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн тусгай зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийн чиглэлийг нэмэгдүүлэхээр материал бүрдүүлэн Гаалийн ерөнхий газарт хүргүүлж, Гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зөвшөөрлөө авсан бөгөөд улс хоорондын тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авахаар Зам тээврийн, хөгжлийн яамд материалаа хүргүүлсэн.

Тав. Компанийн зах зээлийн хүрээгтэлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд

Шуудангийн бүх төрлийн үйлчилгээг сурталчлан таниулах, хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх зорилгоор өдөр тутмын сонин, чөлөөт хэвлэлүүд, мөн гэрээт сэтгүүлүүдэд мөнгөний дугтуй, онлайн хэвлэл захиалга, дотоод илгээмжийн урамшуулал, татварын буцаан олголт, өвлийн өвгөний захидал, хэвлэл захиалгын жагсаалт, гар зураг, эссэ бичлэгийн уралдаан,

“Хас банк” “Төрийн банк”, “Анд глобал” ХХК-тай хамтран ажиллах тухай 14 төрлийн контентийг давхардсан тоогоор 70 удаа хэвлүүлэн гаргасан.

Бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор мөнгөний дугтуй, логистик үйлчилгээ, буухиа шуудангийн үйлчилгээний талаар 9 төрлийн 65 мянган ширхэг сурталчилгааны материал бэлтгэн хэвлүүлж, хэрэглэгчдэд хүргэсэн.

Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2017, Төрийн өмчийн нээлттэй хаалганы өдөрлөгт нийт 80 гаруй байгууллага оролцож, Монгол шуудан ХК шилдэг байгууллагаар шалгарсан. Мөн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг, хөрөнгө оруулагч үндэстэн чуулга уулзалтад оролцож, компанийн үйл ажиллагаат харилцагч үйлчлүүлэгчид сурталчилсан. Энэ үеэр компанийн үндсэн үйл ажиллагааны танилцуулга, мэндчилгээ, хөнгөлөлт урамшуулал болон иргэдэд шуудангийн үйлчилгээг нэг дороос авах боломжоор хангаж ажиллав.

“АПУ” ХК-тай хамтран “Мундаг Маамуу” захидал, гар зургийн уралдааныг 2 насны ангилалтайгаар зохион байгуулж энэхүү хамтын ажиллагааны хүрээнд нийслэлийн Налайх дүүргийн 10 жилийн 119 дүгээр сургууль, Хан-Уул дүүргийн математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 52 дугаар тэргүүний сургууль дээр очиж өдөрлөг зохион байгуулсан ба нийт 15000 мянга гаруй захидал хүлээн авч, 360 шилдэг бүтээл шалгаруулан, бүтээлийн эздэд шагнал гардууллаа. Компанийн 30 ажилтны 5-9 насны хүүхдүүдийг “АПУ” ХХК-ийн сүүний үйлдвэртэй танилцуулж, гарын бэлэг өгч бяцхан хүүхдүүдийг баярлуулав.

Логистик үйлчилгээ талаар 10000 ширхэг сурталчилгааны материал, Төв шуудангийн гадна талын 2 самбар дээр гадаад хэвлэл захиалга, “Мундаг маамуу” захидал, гар зургийн уралдаантай холбоотойгоор хулдаасан хэвлэл, 500 ширхэг захидлын аяны блакат, 20000 мянган ширхэг дугтуй хэвлүүлэн тараасан.

Vision Group-тэй хамтран, сошиал орчинд идэвхжүүлэлт хийснээр www.mongolpost.mn сайтад хандах хандалтын тоо 700 мянга, фэйсбүүк хуудсаар дагагчийн тоо 20 000-д хүрсэн.

Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайланг анх удаа Англи, Монгол хэл дээр А4 хэмжээтэй матт бүрэлттэйгээр 100 ширхгийг хэвлүүлж, ТУЗ-ийн гишүүд болон хувьцаа эзэмшигчид, компанийн захирлын зөвлөлийн гишүүдэд тараасан.

Компанийн ребрендингийн ажлын хүрээнд одоо хэрэглэгдэж байгаа логон дээр хөгжүүлэлт хийн, “SIKR” компаниар брэндбүүк хийлгэж, ТУЗ-аар батлуулсан.

Зургаа. Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, технологийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах чиглэлээр

Аймгийн төвөөс сумдад хүргэх шуудангийн хүргэлтэнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор зарим сумдын шууданчтай 7 хоног тутам, аймгийн шууданчтай өдөр тутам холбоо барьж шалган тогтмол хяналт тавьж байна. Архангай аймгийн Цэцэрлэг сум, Хайрхан сумдууд нь аймгийн төвөөсөө алслагдсан, өөрийн тээврээр хүргэхэд зардал их гардаг, мөн дайврын унаа бага явдаг зэргээс шалтгаалан сумдын шууданг тогтмол солилцдог болгох үүднээс Улаанбаатар хотоос долоо хоногийн Пүрэв гараг бүр шууд хүргэдэг болгов.

БНСУ-ын шуудангаар дамжин илгээгдэж байгаа гарах буухиа шуудангийн ялган боловсруулах үйл явцыг хөнгөвчлөх, хурдасгах үүднээс чиглэл маршрут, жин, төрлийн талаарх мэдээг өдөр бүр транзит шуудангийн байгууллагад явуулан, Япон, ОХУ, Гонгконг улсуудаар нээлттэй транзит хийн дамжуулж буй улс орнуудтай хийх илгээмжийн төлбөр тооцоог 2017 оны эхний хагас жилийн CP82 хүснэгтийн дагуу IPS програмд өөрчлөлт, тохиргоог хийн ажиллаа.

Ашиглалт үйлчилгээнд гарсан чанарын гологдол, гомдлыг нэгтгэн сар тутамд, ДШХ болон EMS кооперативийн шуурхай зар, мэдээг орчуулан тухай бүр нь www.info.mongolpost.mn сайтаар дамжуулан нийт шууданчдад мэдээлж байна. Эхний хагас жилийн байдлаар нийт 71 хэрэглэгчдээс гомдол, санал хүлээн авч, шуурхай арга хэмжээ авч, дөрвөн хэрэглэгчийн хохирол барагдуулсан ба үүнээс нэг хэрэглэгчийн 96,000 төгрөгийн хохирлыг Турк Эйрлайнс ХХК-аар, хоёр хэрэглэгчийн 161,907 төгрөгийн хохирлыг улс

хоорондын тооцоогоор, нэг хэрэглэгчийн 15,700 төгрөгийг байгууллагын зардлаар барагдуулаад байна.

Шуудангийн солилцоо

Тайлант хугацаанд шуудангийн сүлжээг хөгжүүлэх, сүлжээний байнгын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах хүрээнд дотооддоо автотээврээр 16108 богц буюу 128729.3 кг шуудан, агаараар 1333 богц буюу 13949.4 кг, төмөр замаар 4938 богц буюу 15279 кг орон нутгийн шуудан, Улаанбаатар хотын дотор 17390 богц буюу 93054.3 кг, улс хооронд газраар 437 богц буюу 2476.4 кг, агаараар 9105 богц буюу 69492,7 кг, өөрийн тээврээр 883 богц буюу 5239,4кг шуудан солилцож хүргэсэн.

Нийт 605339 ширхэг бичиг захидал, боодол, 6456 ширхэг гадаад, дотоод илгээлт, 18260 ширхэг гадаад, дотоод буухиаг ялган боловсрууллаа.

Үйлчилгээний чанарыг сайжруулах

Буухиа шуудангийн болон илгээлтийн лавлагааны чанарыг сайжруулах зорилт тавин ажиллаж, 1-р шатны лавлагаанд чанартай хариу өгөх, зохих актуудаар лавлагааг эцэслэж хаах ажлыг өдөр тутамд хийж гүйцэтгэж байна. Мөн буухиа шуудангийн лавлагааны чанарын үзүүлэлт сайжрахгүй байгаатай холбогдуулан Дэлхийн шуудан холбоо руу асуулга албан бичиг явуулан 4-р сарын лавлагааны мэдээнд анализ дүгнэлт хийснээр гаргаж байгаа алдаа дутагдлыг илрүүлэн, энэ талаар операторуудад заавар зөвлөгөө өгөн чанарын үзүүлэлтийг сайжруулахаар ажиллаж байна. Үүний үр дүнд буухиа шуудангийн 5-р сарын чанарын үзүүлэлт 92% болж өссөн байна. Цаашид чанарын үзүүлэлтийг 95-98% хүргэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Буухиа шуудан солилцож буй бүх улс орнуудад хүргэж гардуулагдах хяналтын хугацааг шинэчлэн тогтоож мөрдөн ажиллаж байна.

Орох, гарах илгээлт, бичиг захидлын CN 48 нөхөн төлбөрийн орох акт 25, гарах акт 13 ширхэг актыг шийдвэрлэсэн. Хэрэглэгчдэд учирсан хохирлыг нөхөн барагдуулах журмыг шинэчлэн боловсруулж байна.

I улиралд төөрч ирсэн илгээмжүүдийг дахин чиглүүлэхтэй холбогдон гарч байгаа тээврийн зардлыг холбогдох улсуудаас гаргуулахаар Хятад, БНСУ, АНУ, Япон, Тайланд, Ирланд, Герман зэрэг улсуудаас 1453,77 SDR-ийн тээврийн төлбөрийг нэхэмжилсэн бөгөөд одоогоор 455 SDR-ийн төлбөрийн батлуулан 1 улирлын улс хоорондын тооцоонд оруулаад байна

Улс орнуудаас ирсэн 105 ширхэг актанд хүлээн авч зохих хариуг илгээсэн ба гэмтэл, зөрчилтэй хүлээн авсан илгээмжийн талаарх 220 ширхэг актыг үйлдэн улс орнуудын шууданд явуулж зохих асуудлуудыг шийдвэрлээд байна.

Долоо. Бусад ажлын хүрээнд

Нийт системийн хэмжээнд Мэдээллийн технологийн програм хангамж, техник хангамж, сүлжээний засвар үйлчилгээг алсын зайнаас болон биет байдлаар очиж үзлэг хийх тогтмол график гарган мөрдүүлэн ажиллаж байна. Аймгуудын ШҮГ-уудад хяналтын камерын системийг суурилуулах судалгаа, зохион байгуулалтыг хийсэн ба Сэлэнгэ ШҮГ, Алтан булаг, Замын-Үүдэн логистикийн төвд хяналтын камер суурилуулсан. Компанийн гадаад шуудан солилцоо Транзит тээврийн /IPS2014/ системийн аппликашин болон мэдээллийн баазыг нөөцлөн, сайжруулсан үзүүлэлт бүхий /Dell R530/ серверт шилжүүлсэн. Ухаалаг шуудангийн систем /Smart Post/-ээс компанийн үндсэн системүүдийн нэг /POSTNET v3/ систем хоёрын хооронд мэдээлэл солилцох кросс /1 гигабайт / холболт хийв.

POSTNETv3 систем дээр гарч байгаа алдаа дутагдлыг засан, төв шуудангийн хэсэг нэгжүүд болон аймаг, салбарын өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Замын цагдаагийн ерөнхий газрын лицензийн төвтэй хамтарч жолооны эрхийн үнэмлэх хүргэх, үүнд шуудангийн 51А салбар болон хэрэглэгчид онлайнаар жолооны үнэмлэхээ захиалан хүргүүлэх боломжтой болсон www.mongolpost.mn/license хаяг дээр бүртгэлийн програм хийгдсэн.

What3words 3м*3м хэмжээст хаягжилтыг www.mongolpost.mn холбож ажиллагаанд оруулсан. Ачаа, тээш хадгалах үйлчилгээний програмын хөгжүүлэлт хийн амжилттай нэвтрүүлсэн.

Компанийн танилцуулгын цахим хуудас болох www.mongolpost.mn -нд илгээмжийн байршил шалгах цэсийг хот дотор, монголоос гарсан болон орж ирсэн илгээмжүүдийг IPS болон Postnet системүүдээс шүүлт хийдэг болсон.

Онлайн сэтгүүл, хэвлэл захиалгын нэгдсэн цахим хуудас www.postnews.mn –ыг ашиглалтад оруулан банкнуудтай холбох онлайн төлбөр тооцоог картаар болон дансаар төлбөр төлөх боломжтой болсон ба төстийн үе шат амжилттай явагдаж дууссан.

Мэдээллийн сүлжээний тоног төхөөрөмж, техник хэрэгслүүдийн ашиглалтыг сайжруулах, засвар үйлчилгээ, заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

Тайлант хугацаанд шуудангийн үндсэн нэр төрлийн болон уламжлалт шуудангийн үйлчилгээг идэвхжүүлж, жилийн дундаж өсөлтийг ханган ажиллах зорилтын хүрээнд бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Цаашид үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг цаг үеийн нөхцөл байдалд тулгуурлан, шинэ шатанд хөгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Хүргэлтийн бизнесийг өргөжүүлэх зорилтын хүрээнд жолооны үнэмлэхний хүргэлт, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн албан бичгийн хүргэлт, гибрид шуудангийн хүргэлт, торгуулийн хуудасны хүргэлтийг өргөжүүлэх чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулж ажилласан ба бүх банкны картын хүргэлт, шүүхийн бичиг мөн санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор салбар нэгжийн үйл ажиллагаа, шуудангийн ажилчдын идэвхи санаачлага болон хариуцлагыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөж байна.

Дотоодын хяналт шалгалтыг сайжруулах зорилгоор бүх салбар нэгжүүдэд санхүүгийн шалгалтыг хийж шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал илэрсэн салбар нэгжүүдэд арга хэмжээ авч зөрчлийг цаг тухайд нь арилгуулж, зөрчил дутагдал гарсан ажилтнуудад албан тушаал бууруулах хүртэл арга хэмжээ авч ажиллалаа.

Логистик үйлчилгээний бизнесийг хөгжүүлэх зорилтын хүрээнд дотоод болон хил дамнасан и-худалдааны үйлчилгээг нэвтрүүлсэн. Гаалийн ерөнхий газрын тавьсан шаардлагын дагуу Алтанбулаг дахь хилийн бүсэд шуудан солилцох төвийг үйл ажиллагаанд оруулан ажиллаж байна.

Сонгино хайрхан Авто тээврийн төв буюу Драгон төвд Шуудангийн ачаа тээвэр, тээш хадгалалтын төвийг нээж, зорчигч тээврийн автобусаар явдаг дайвар ачааг нэгдсэн журманд оруулж, засвар үйлчилгээ хийж, шинэ үйлчилгээ эхлүүлсэн.

Цаашид ОХУ болон БНХАУ-ын холбогдох байгууллагуудтай хамтран транзит шуудангийн үйлчилгээг эхлүүлэхээр зорилго тавин ажиллаж байгаа бөгөөд хамтын ажиллагааны хамтын ажиллагааны тогтвортой байдлыг хангах, цаашдын үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллавал өсөн нэмэгдэх ирээдүйтэй юм.

Бид 2017 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг амжилттай үргэлжлүүлэх, гарч байгаа хүндрэлийг даван туулах, шинээр гарц хайх, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх зэрэгт дүгнэлт хийсний үндсэн дээр дараах зорилго, зорилтуудыг дэвшүүлж ажиллахаар төлөвлөж байна.

1. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх замаар шуудангийн уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, шуудангийн байгууллагын шинэ өнгө төрхийг тодорхойлж, орчин үеийн мэдээллийн технологид суурилсан шуудангийн үндсэн сүлжээг өргөтгөх зорилгын хүрээнд:
 - Компанийн шинэ өнгө төрхийг тодорхойлох Ребрэндийг хийж, бүтээгдэхүүн үйлчилгээг шинэ өнгө төрхтэйгээр идэвхжүүлэх
 - Шинээр жишиг салбарыг ашиглалтанд оруулах
 - POST SHOP үйлчилгээг Улаанбаатар хотод болон орон нутагт нэвтрүүлэх
 - Илгээмжийн худалдааны нэр төрлийг нэмэгдүүлж, бүртгэл хяналтыг сайжруулах
 - Санхүүгийн болон технологийн хяналтыг сайжруулах зөрчил дутагдалгүй ажиллах
 - Маркетингийн идэвхижүүлэлтийг нэмэгдүүлэх
 - Үйлчилгээний чанарт анхаарч, гардуулалт солилцоог нэмэгдүүлэх
 - Аймгийн ШҮГ-уудын үйл ажиллагаанд хяналт тавих, идэвхижүүлэлт хийх
 - Өр авлагыг бууруулах
2. Дотоодын болон олон улсын тээвэр зууч, транзит тээвэр, логистикийн үйлчилгээг эхлүүлэх зорилгын хүрээнд:
 - Олон улсын болон дотоодын логистик, тээвэр зуучийн үйлчилгээг нэвтрүүлэх дэд бүтцийн болон технологийн шийдлүүдийг тодорхойлох, шийдвэрлэх;
 - Олон улсын транзит шуудангийн үйлчилгээг өргөжүүлэх, хөгжүүлэх;
 - Дотоод логистик тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх;
 - Дотоод логистик тээврийн үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлэх, бүх аймгийн төвүүдэд логистик үйлчилгээг эхлүүлэх;
 - Гаалийн бүрдүүлэлт хийх мэргэжилтэн бэлдэх, бүрдүүлэлт хийж, олон улсын тээвэр зуучийн үйлчилгээг эхлүүлэх;
 - Шуудангийн ачаа тээшийн төвийг орон нутагт байгуулахаар ажиллаж байна.

“МОНГОЛ ШУУДАН” ХК